



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хан-Уул “Зам засвар, арчлалт” ОНӨААТҮГ-ын 2023 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2024/25/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn	Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Аккаунт траст аудит ХХК-ийн захирал П.Наранцэцэг Утас: 99130778 Цахим хаяг: acctrust.audit@gmail.com Ахлах аудитор Ч.Замбага Утас: 99127118 Аудитор: П.Саранчимэг Утас: 89986879
Улаанбаатар хот 2024он	

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.03.15

№

464

танай _____-ны № _____-г

ХАН-УУЛ ЗАМ ЗАСВАР, АРЧЛАЛТ
ОНӨААТҮГ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Ц.ГАН-ЭРДЭНЭ ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хан-уул зам засвар, арчлалт ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Хан-уул зам засвар, арчлалт ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлага болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд 6 зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 74.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

002022923

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд
хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	216,909,812.06	1,249,956,999.03
312	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	30,701,037.08	169,202,925.98
33	Дансны авлага	127,445,084.10	72,702,804.39
33.1	Татвар, НДШ-ийн авлага	127,313,084.10	72,570,804.39
33.2	Орон нутгийн авлага	132,000.00	132,000.00
34	Урьдчилж гарсан зардал	-	624,449,608.95
34.1	Бараа материал	58,763,690.88	383,601,659.71
39	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,015,659,962.99	1,708,849,675.57
392	Үндсэн хөрөнгө	1,014,755,275.56	1,708,668,738.14
39300	Биет бус хөрөнгө	904,687.43	180,937.43
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,232,569,775.05	2,958,806,674.60
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	98,145,670.63	9,762,316.00
41	Богино хугацаат өр төлбөр	98,146,670.63	9,762,316.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	4,562,616.00
41363	Татварын өр	45,549,737.63	-
41430	Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого	52,596,933.00	5,199,700.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,134,423,104.42	2,949,044,358.60
51	Засгийн газрын хувь оролцоо	1,134,423,104.42	2,949,044,358.60
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	565,955,000.00	738,735,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	568,468,104.42	2,210,309,358.60
512	Өмнөх үеийн үр дүн	158,520,465.71	568,468,104.44
513	Тайлант үеийн үр дүн / орон нутаг /	409,947,638.71	1,641,841,254.16
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,232,569,775.05	2,958,806,674.60

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан
2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	31,611,785.24	122,455,284.38
3	Борлуулалтын өртөг	-	-
4	Нийт ашиг (алдагдал)	31,611,785.24	122,455,284.38
7	Татаас санхүүжилтийн орлого	2,633,881,263.00	5,621,434,480.00
11	Ерөнхий ба удирдлагын зардал	2,209,995,671.90	3,919,621,704.20
19	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	455,497,376.34	1,824,268,060.18
20	Орлогын татварын зардал	45,549,737.63	182,426,806.00
21	Татварын дараах ашиг (алдагдал)	409,947,638.71	1,641,841,254.18
23	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	409,947,638.71	1,641,841,254.18
28	Орлогын нийт дүн	409,947,638.71	1,641,841,254.18

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан
2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	565,955,000.00	158,520,465.71	724,475,465.71
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	565,955,000.00	158,520,465.71	724,475,465.71
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	409,947,638.71	409,947,638.71
9	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	565,955,000.00	568,468,104.42	1,134,423,104.42
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	565,955,000.00	568,468,104.42	1,134,423,104.42
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	1,641,841,254.18	1,641,841,254.18
14	Өмчид гарсан өөрчлөлт	172,780,000.00	-	172,780,000.00
17	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	738,735,000.00	2,210,309,358.60	2,949,044,358.60

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12 дугаар сарын 31	2022 оны 12 дугаар сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,718,089,981.24	5,749,089,464.38
1.1.1	Татаас, санхүүжилтийн орлого	2,633,881,263.00	5,621,434,480.00
1.1.2	Бусад мөнгөн орлого	84,208,718.24	127,654,984.38
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,223,061,030.49	4,875,736,525.48
1.2.1	Ажиллагчдад төлсөн	552,128,649.00	849,627,299.50
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	79,449,943.71	123,020,524.09
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	4,772,600.00	5,048,510.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	25,337,720.00	31,491,245.16
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	119,479,780.00	189,135,142.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	27,636,770.78	210,478,530.45
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	135,000.00	614,925.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	919,091,616.25	3,466,320,349.28
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	495,028,950.75	873,352,938.90
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгө орлогын дүн (+)	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	573,405,000.00	734,851,050.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	573,405,000.00	734,851,050.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(573,405,000.00)	(734,851,050.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(78,376,049.25)	138,501,888.90
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	109,077,086.33	30,701,037.08
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	30,701,037.08	169,202,925.98

Хан-уул Зам засвар, аргачлал ОНӨААТҮГ-ын 2023 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мян.төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 оны төлөвлөгөө	2024 оны гүйцэтгэл	Зөрүү
1	Нийт орлого	0	12,911,184.0	5,743,889.8	(7,167,294.2)
1.1	Нийтлэг бус татварын орлого	Төгрөг	20,000.0	20,000.0	-
1.2	Борлуулалтын хөнгөлөлт	Төгрөг	-	-	-
1.3	Дээд шатны төсвийн эрх захирагчаас олгосон санхүүжилт	Төгрөг	12,891,184.0	5,621,434.5	(7,269,749.5)
1.4	Хандив тусламжийн орлого	Төгрөг	-	-	-
1.5	Бусад орлого	Төгрөг	-	102,455.3	102,455.3
2	Нийт зардал	Төгрөг	12,891,184.0	3,919,621.7	1,824,268.1
2.1	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	0	-	-	-
2.2.1	Цалин	Төгрөг	1,246,843.0	849,627.3	(397,215.7)
2.2.2	НДШ	Төгрөг	180,794.0	123,020.5	(57,773.5)
2.2.3	Байр ашиглалттай холбоотой зардал	Төгрөг	33,240.1	31,612.9	(1,627.2)
2.2.4	Бичиг хэрэг	Төгрөг	6,909.5	4,540.8	(2,368.7)
2.2.5	Тээвэр, шатахуун	Төгрөг	29,643.0	98,512.0	68,869.0
2.2.6	Шуудан холбоо	Төгрөг	6,000.0	2,990.2	(3,009.8)
2.2.7	Хог хаягдал зайлуулах хортон мэрэгч устгах	Төгрөг	4,020.0	413.0	(3,607.0)
2.2.8	Сэлбэг хэрэгсэл	Төгрөг	111,755.1	96,979.5	(14,775.6)
2.2.9	Засвар үйлчилгээний зардал	Төгрөг	4,402,499.6	1,114,461.5	(3,288,038.1)
2.2.11	Хангамжийн материал	Төгрөг	-	-	-
2.2.12	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	Төгрөг	-	480.0	480.0
2.2.13	Нормын хувцас, зөөлөн эдлэл	Төгрөг	14,830.0	4,950.0	(9,880.0)
2.2.14	Хоол хүнс	Төгрөг	-	-	-
2.2.15	Тоног төхөөрөмж	Төгрөг	765,978.8	215,031.3	-
2.2.16	Тавилга	Төгрөг	4,320.0	-	-
2.2.17	Томилолтын зардал	Төгрөг	10,000.0	-	-
2.2.18	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	Төгрөг	6,012,100.9	1,179,275.7	(4,832,825.2)
2.2.19	Аудит баталгаажуулалт зэрэглэл тогтоох	Төгрөг	2,500.0	2,500.0	-
2.2.20	Даатгалын үйлчилгээ	Төгрөг	2,500.0	614.9	(1,885.1)
2.2.21	Тээврийн хэрэгслийн татвар	Төгрөг	1,500.0	726.5	(773.5)
2.2.22	Тээврийн хэрэгслийн оношилгоо	0	700.0	132.0	(568.0)
2.2.24	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	Төгрөг	500.0	391.3	(108.7)
2.2.25	Ерөнхий ба удирдлагын зардал	0	-	58.5	58.5
2.2.26	Орлогын татварын зардал	Төгрөг	-	164,928.8	164,928.8
2.2.27	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0	4,550.0	590.0	-
2.2.28	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	Төгрөг	50,000.0	27,785.0	(22,215.0)
2.2.29	Бусад зардал	Төгрөг	-	-	-
0	Үйл ажиллагааны зардал	Төгрөг	12,891,184.0	3,919,621.7	1,824,268.1
3	Татвар төлөхийн дараах ашиг алдагдал	Төгрөг	-	1,824,268.1	-
4	Орлогын татвар	Төгрөг	-	182,426.8	-
5	Цэвэр ашиг алдагдал	Төгрөг	-	1,641,841.3	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт залруулагдаагүй 32,189.7 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 32,189.7 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүллээ.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд худалдан авсан бараа ажил үйлчилгээний 32,189.7 мянган төгрөгийн худалдан авалтын и баримт татварын цахим системд бүртгэгдээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна.	1	32,189.7	-	-	1	32,189.7			-	-	-	-
Дүн	1	32,189.7	-	-	-	32,189.7			-	-	-	-

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Хан-уул Зам засвар, аргачлал ОНӨААТҮГ-ын 2023 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 44,506.3 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 44,506.3 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/Мянган төгрөгөөр/					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэх 5 мэдээллийн хугацааг хоцроосон байна .	1						1	
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тайлант онд зарласан ХУЗЗАОНӨААТҮГ/202301013/03/01 тоот тендерээр 306,887.5 мянган төгрөгийн ажил гүйцэтгэхээр гэрээ хийсэн боловч 412,771.2 мянган төгрөгийн ажил гүйцэтгэж төлбөр төлөгдсөн байна. Үүнээс Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-т заасны дагуу гэрээний дүнгээс 20 хувийг тооцон хасахад 44,506.3 мянган төгрөгийн илүү худалдан авалт хийсэн.	1	44,506.3	-	-	1	44,506.3		
Дүн	1	44,506.3	-	-	1	44,506.3	1	-
Нийт дүн	2	44,506.3	-	-	1	44,506.3	1	-